

ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН САНХҮҮ,
ТӨРИЙН САНГИЙН ХЭЛТСИЙН 2017 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2017 оны 12-р сарын 04-ны өдөр

Улаанбаатар хот

Дүүргийн Нийгэм эдийн засгийн үндсэн чиглэл, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх, нийслэл, дүүргийн удирдлагуудаас өгөгдсөн чиг үүргийг хэрэгжүүлэх, дүүргийг засаг даргын өмнөө тавьсан зорилтуудыг хэрэгжүүлж, орлогоороо зарлагаа нөхөн биеэ даан ажиллах зорилтын хүрээнд чиг үүргээ хэрэгжүүлэн ажиллаж байна.

1.1 Дүүргийн төсвийн тэнцвэрт байдал, эдийн засгийн бие даасан байдлыг бэхжүүлэн, нутгийн захиргааны байгууллагаас дэвшүүлсэн зорилтыг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө санхүүгийн нөөц бүдүүлэн ажиллана.

1.1.1 Орон нутгийн төсвийн төлөвлөлт, хуваарилалтыг боловсронгуй болгох, орлогын шинэ эх үүсврийг илрүүлэх, түүнийг бүрдүүлэх, зардал хэмнэх, чиглэлээр санал боловсруулан холбогдох хэлтэс албадтай хамтран ажиллана.

Хэрэгжилт, биелэлт:

Дүүргийн төсөвтэй харилцагч, нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж байгууллага, иргэдийг татвар төлөлтөд бүрэн хамруулах, татварын өр барагдуулах ажлыг эрчимжүүлэх чиглэлээр татварын орлогын бүрдүүлэлтэд байнгын хяналт тавин ажиллаа.

Улс, нийслэл, дүүргийн төсвийн орлогын төлөвлөгөөг жигд ханган биелүүлэх ажлын хүрээнд орлого тасрах шалтгаан нөхцлийг судлан, дутуу төлөлтийг барагдуулах, орлогын бааз суурийг өргөжүүлэх, төсвийн орлогын тогтвортой эх үүсврийг нэмэгдүүлэх, дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлж буй татварын болон нийгмийн даатгалын шимтгэлийн хуримтлагдсан өртэй аж ахуйн нэгж байгууллагын өрийг барагдуулах чиглэлээр Дүүргийн Засаг даргын А/483 дугаар захирамжаар байгуулагдсан “Ажлын хэсэг”-ийг үргэлжлүүлэн ажиллуулж байна.

Төсвийн орлолын төлөвлөгөөг хангах, биеэ даасан байдлыг бэхжүүлэхэд чиглэгдсэн ажлуудыг Татварын хэлтэстэй хамтран дэс дараатай хэрэгжүүлэн, иргэд, аж ахуйн нэгжүүдийг татвар төлөлтөд бүрэн хамруулан татварын орлогын бүрдэлтэд байнгын хяналт тавин ажилласнаар 2017 оны 12 дугаар сарын 04-ны өдрийн байдлаар өссөн дүнгээрээ Улсын төсвийн орлого 61 033 183,6 мянган төгрөг төлөвлөгдснөөс 63 926 367,7 мянган төгрөгд хүрч 104.7 %-ийн, Нийслэлийн төсвийн орлого 67 469 159,8 мянган төгрөг төлөвлөгдснөөс 60 120 825,7 мянган төгрөгд хүрч 89.1 %-ийн, Орон нутгийн төсвийн орлого 55 169 842,4 мянган төгрөг төлөвлөгдснөөс 55 439 527,6 мянган төгрөгд хүрч

100.5 %-иар тус тус давуулан биелүүлж, дүүргийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, нийгэм эдийн засгийн үндсэн чиглэлийн биелэлтийг хангахад хөрөнгийн эх үүсврийг бий болгож, орлогоороо зарлагаа нөхөн биеэ даан ажиллах нөхцлийг бүрдүүлэн ажиллаж байна.

Хүрч буй үр дүн: Улс, нийслэл, орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг хүлээж буй гүйцэтгэлээр 103.9 %-иар давуулан биелүүлж, орлогоороо зарлагаа нөхөн биеэ даан ажиллах нөхцлийг ханган ажиллаж байна.

1.1.2 Төсвийн орлогын төлөвлөгөөг жигд хангах замаар хөрөнгийн эх үүсврийг бий болгох.

Хэрэгжилт, биелэлт:

Дүүргийн Засаг даргын “Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар, агаарын бохирдлын төлбөр, авто зам ашигласны төлбөр хураах ажлыг зохион байгуулах тухай” 2017 оны А/15 дугаар захирамжаар Дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээнд авто тээвэр болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар, агаарын бохирдлын төлбөр, авто зам ашигласны төлбөр хураах ажлыг тогтоосон хугацаанд хөнгөн шуурхай, татвар төлөгчдөд чирэгдэлгүй нэг цэгийн үйлчилгээгээр дамжуулан зохион байгуулж, хууль тогтоомжийн дагуу холбогдох төсөвт төвлөрүүлэх ажлыг зохион байгуулан хэрэгжилтэд нь хяналт тавин ажиллаж байна.

Дүүргийн Засаг даргын “Хуулийн хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах тухай” 2017 оны А/45 дугаар захирамжаар дүүргийн нутаг дэвсгэрт бараа борлуулсан, ажил гүйцэтгэсэн, үйлчилгээ үзүүлсэн албан татвар төлөгч албан татвар, суутган татвар төлөгчдийг хамруулан Татварын Ерөнхий Хууль, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль, Нийслэл хотын албан татварын тухай хуулийн хэрэгжилтийг нийслэлийн нутаг дэвсгэрт хангуулах ажлыг зохион байгуулж, улс, орон нутгийн төсвийн орлогыг бүрдүүлэх ажлыг зохион байгуулж, гүйцэтгэлд нь хяналт тавин ажиллаж байна.

Шүүхийн шийдвэрээр улсын тэмдэгтийн хураамжийн буцаалтын 42.5 сая төгрөгийг 170 иргэн, аж ахуйн нэгж байгууллагад буцаан олгосон байна. Мөн татварын хэлтсээс ирүүлсэн данс андуурсан зарлагын залруулгын 31.6 сая төгрөгийн 13 ширхэг гүйлгээнд залруулга хийж ажилласан.

Дүүргийн хууль хяналтын байгууллагад шалгагдаж байгаа эрүү иргэний 314 хэргийн холбогдолтой 661 ширхэг 289 сая 774.7 мянган төгрөгийн эд хөрөнгөнд зах зээлийн дундаж үнэлгээ тогтоох комиссын ажлыг дүүргийн хэмжээнд зохион байгуулан ажиллаа.

Тайлант онд авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын тухай хууль, агаарын бохирдлын төлбөрийн тухай болон авто замын тухай хууль, Нийслэлийн Засаг даргын 2017 оны А/09 тоот захирамжийг хэрэгжүүлэх зорилгоор дүүргийн Засаг даргын 2017 оны А/15 тоот захирамжаар ажлын хэсгийг томилон ажилласнаар дүүргийн 12-р хорооны байр, 7 буудал дахь Эмон трейд худалдааны төв, Засаг даргын Тамгын газрын “Нэг цэгийн үйлчилгээний танхим”, Татварын хэлтсийн нэг цэгийн ажлын байранд Улсын байцаагчдыг

ажиллуулан, тээврийн хэрэгсэл эзэмшигч иргэдийн татвар, төлбөрийг 2017 оны 01 дүгээр сараас эхлэн тээврийн хэрэгслийн улсын дугаарын сүүлчийн оронгоор ангилах, цагдаагийн хэлтэстэй хамтран тээврийн хэрэгслийн бичиг баримт хураан авч, татвар, төлбөрийг хураах ажлыг зохион байгуулж, эрчимжүүлэн ажиллаж ирлээ.

Дүүргийн Засаг даргын 2017 оны А/652 дугаар захирамжаар 2017 оны 10 дугаар сард авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар, агаарын бохирдлын төлбөр, авто зам ашигласны төлбөр төлөлтийн хяналтын үзлэг, шалгалтыг батлагдсан удирдамжийн дагуу зохион байгуулан, дүүргийн 1-19 хороодод болзолт уралдаан зарлан дүнг гарган ажилласан болно. Энэхүү ажлын хүрээнд татварт хамруулвал зохих нийт 9043 тээврийн хэрэгсэл хамрагдахаас 1034 тээврийн хэрэгслийг татварт хамруулж, 56.7 мянган төгрөгийн татварыг хураан авч, 797 тээврийн хэрэгслийн хасагдах хүсэлтийг хүлээн авч, зохих асуудлуудыг шийдвэрлэн ажилласан байна.

Мөн дүүргийн Засаг даргын 2017 оны А/149 дүгээр захирамжаар төсвийн орлогын тогтвортой орчинг бүрдүүлэх, татварын бааз суурийг өргөжүүлэх, орлогын төлөвлөгөөг татварын нэр төрөл тус бүрээр нь ханган биелүүлэх, нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль, Нийслэл хотын албан татварын тухай хууль, үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуулиудын хэрэгжилтийг эрчимжүүлэх, дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй бизнес эрхлэгч хувь хүн, иргэд, хуулийн этгээдийн нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн урамшууллын нэгдсэн системд холбогдсон эсэх, цахим төлбөрийн баримт хэвлэж өгөхгүй явдлыг богино хугацаанд арилгах зэрэг ажлуудыг зохион байгуулах ажлын хэсгийг байгуулан, үл хөдлөх эд хөрөнгө эзэмшигч хувь хүн, иргэн, хуулийн этгээдийн тооллого, бүртгэлийг нутаг дэвсгэрийн зарчмаар явуулж, татварт бүрэн хамруулах, хувь хүн, иргэн, хуулийн этгээдийн түрээсийн гэрээ хэлэлцээр, аж ахуйн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөлтэй эсэхийг хянан шалгах, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах шат дараалсан арга хэмжээнүүдийг зохион байгуулан, үр дүнг тооцон ажиллаж байна.

Дүүргийн хууль хяналтын байгууллагад шалгагдаж байгаа эрүү, иргэний 2237 хэргийн холбогдолтой 4 тэрбум 392.5 сая төгрөгийн эд хөрөнгөнд зах зээлийн дундаж үнэлгээг хийж, Үнэлгээ тогтоох комиссын ажлыг дүүргийн хэмжээнд зохион байгуулан ажиллаа.

Шүүхийн шийдвэрээр улсын тэмдэгтийн хураамжийн буцаалтын 497 сая 705.6 мянган төгрөгийг 1476 иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудад буцаан олгосон байна.

Хүрч буй үр дүн: Улс, нийслэл, орон нутгийн төсвийн орлогын эх үүсврийг нэмэгдүүлэн, төсөвлөсөн орлогын төлөвлөгөөг биелүүлж, өмнөө тавьсан зорилтоо ханган, орлогоороо зарлагаа нөхөн, бүрэн биеэ даан ажиллаж байна.

1.2 Төсөвт байгууллагын төсвийн сахилга, төсвийн хөрөнгийн зориулалтын үр ашгийг дээшлүүлж, урсгал зардлыг бууруулах.

1.2.1 Төсвийн зарцуулалтын хүсэлт баталгааг гаргуулан авч, төсвийн сар, улирлын батлагдсан хуваарь, төсөвтэй харьцуулан хянаж, санхүүжилтийг сар бүр олгох.

Хэрэгжилт, биелэлт:

Төсвийн гүйцэтгэлийн зарлагын мэдээний тодруулгыг нэгтгэн төсвийн зардлын гүйцэтгэлийн нөлөөллийг тооцон шилэн дансны мэдээлэлд оруулсан ба тухайн сард үүссэн өрийг үндсэн байгууллагаас ба төсөв хүрэхгүйгээс гарснаар нь ангилан шаардлагатай ажлыг зохион байгуулж гүйцэтгэлээ.

Батлагдсан төсвийн хуваарийн дагуу Орон нутгийн төсвийн байгууллагуудад хүлээгдэж буй гүйцэтгэлээр 28 тэрбум 012,2 сая төгрөгийн, Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн байгууллагуудад 28 тэрбум 788,2 сая төгрөгийн санхүүжилтийн эх үүсврийг цаг хугацаанд бүрэн олгож ажилласнаар төсвийн зарлага, санхүүжилтээс 0.2%-ийн хэмнэлт гаргаж, гүйцэтгэлд нь хяналт тавин ажиллаа.

Төрийн захиргааны батлагдсан нормативт орон тоог багасгаж ажилласнаар, зарим нэг зардлыг төсвийн орлоготой уялдуулан гаргахгүй хойшлуулснаас, тогтмол зардал болох гэрэл, цахилгаан, халаалт дулаан, ЦБУсны зардлын гэрээ хийгдэж, төлбөр нь сар дамжин хийгдэж байгаагаас тухайн сарын төсөв үлдэгдэлтэй гарч дараа сардаа төлбөр нь төлөгдөх, зарим газар орон тоо дутуу ажилласнаас, төсвийн хэмнэлтийн горимд шилжиж, төсвийн зардлыг хэмнэх бодлогыг хэрэгжүүлсэн, галлагаатай зуухыг сольж, цахилгаанаар халаах туршилт хийж байгаа зэргээс тус тус шалтгаалан зардал хэмнэхэд нөлөөлсөн байна.

Мөн зарим тогтмол зардлуудад бодит хэмнэлтийн тооцоо хийж, үйл ажиллагаандаа хэрэгжүүлж, үр дүнг тооцсноос, өмнөх онд шатахууны болон бичгийн хэргийн зардлын нөөц бэлтгэснээс, урьдчилсан төлбөрт дугаарын суурь хураамжийг 2 сараар урьдчилан төлснөөс, Тамгын газрын хороодод хийгдэх халдваргүйтэл, ариутгал хийх хугацаа хойшилсноос, албан томилолт, гадаад арга хэмжээний зардлыг хойшлуулж зарцуулаагүйгээс, гэрээгээр гүйцэтгэх ажил, үйлчилгээг бага өртгөөр чанартай гүйцэтгэх, үнийн болон чанарын судалгааг хийж, төлөвлөсөн ажлууд тодорхой хугацаагаар хойшлогдсноос, тэтгэвэрт гарах ажилтнуудын тэтгэвэрт гарах хугацаа нь нийгмийн даатгалын тооцоо, ажилласан жилээрээ тооцож үзэхэд хүрээгүй хойшлогдсноос, сарын дундуур гэрээт ажилтнууд ажлаас чөлөөлөгдснөөс, тухайн сардаа ажиллагсадын зэрэг дэвийн нэмэгдлийн тушаал хугацаандаа гараагүйгээс, ном худалдан авах үйл ажиллагаатай холбогдуулан номын үнийн зэрэгцүүлсэн судалгаа тооцоог хийж, худалдан авах ажиллагааг түр хугацаагаар хойшлуулснаас тус тус шалтгаалан үлдэгдэлтэй гарсан байна.

Хүрч буй үр дүн: Хэмнэлтийн горим болон төсвийн үргүй зардлыг бууруулах бодлогыг баримтлан ажилласнаар төсвийн урсгал зардлыг 0,2%-иар хэмнэсэн.

1.2.2 Дүүргийн төсөвтэй шууд харьцдаг байгууллагуудын төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээг шалган хүлээн авч нэгтгэн дүн шинжилгээ хийж, дээд шатны байгууллагад хүргүүлэх.

Хэрэгжилт, биелэлт:

Дүүргийн төсөвтэй харилцагч 66 төсөвт байгууллагуудаас сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн зарлагын мэдээг хугацаанд нь хянан хүлээн авч, баталгаажуулан нэгтгэснээр Дүүргийн төсвийн гүйцэтгэлийн зарлагын болон Орон нутгийн төсвийн орлогын мэдээ, төсвийн зарлагын нэгдсэн мэдээ, төрийн сангийн орлого, зарлагын мэдээ, төсвийн нэгдсэн тэнцлийг хуулийн хугацаанд нь нэгтгэн гаргаж, мэдээний тодруулгыг боловсруулан хугацаанд нь Нийслэлийн Санхүү, төрийн сангийн хэлтэс, дүүргийн статистикийн албанд хүргүүлэх, дүүргийн удирдлагуудыг мэдээллээр ханган ажиллаж ирлээ.

2017 оноос төсөвт байгууллагуудаас сар бүр авдаг төсвийн гүйцэтгэлийн зарлагын мэдээний тодруулыг хийлгэн мэдээтэй хавсарган авдаг журмыг хэвшүүлснээр Төсвийн гүйцэтгэлийн зарлагын мэдээний тодруулгыг нэгтгэн төсвийн зардлын гүйцэтгэлийн нөлөөллийг тооцон шилэн дансны мэдээлэлд оруулсан ба тухайн сард үүссэн өрийг үндсэн байгууллагаас ба төсөв хүрэхгүйгээс гарснаар нь ангилан шаардлагатай ажлыг зохион байгуулж гүйцэтгэлээ.

Хүрч буй үр дүн: Журмын дагуу статистик мэдээ, тайлан хуулийн хугацаандаа бүрэн гарч хэвшсэн ба үр дүнгээр тодорхой бодлогын асуудал боловсруулагдан, удирдлага зохион байгуулалтын ажлууд хийгдэж, удирдлагуудыг мэдээллээр ханган ажилладаг болсноор төлөвлөгөөний биелэлт 100%-тай гарч байна.

1.2.3 Төрийн сангийн банкны дансдын үлдэгдэл, орлогын дансдын хуулга, нягтлан бодох журналаар тухайн өдрийн гүйлгээг тулган шалгаж, нэгдсэн тайланг гаргаж, төрийн сангийн мемориалыг бэлтгэн хэлтсийн удирдлагад танилцуулж, баталгаажуулан архивын нэгж болгон ажиллах.

Хэрэгжилт, биелэлт.

Төрийн сан банкны нягтлан бодох бүртгэлийн дэлгэрэнгүй дансдаар тайлант оны 12-р сарын 07-ны байдлаар өссөн дүнгээр орлогын хуулгаар 147 505 281 999 төгрөг 64 мөнгөний, нягтлан бодох бүртгэлийн мемориал, журналаар зарлагын 18176 ширхэг баримтаар 143 307 160 314 төгрөг 07 мөнгөний гүйлгээг тухай бүрд нь өдрийн гүйлгээгээр тулган шалгаж, төлбөрийн гадаад, дотоод гүйлгээг банк хооронд заавар журмын дагуу хөнгөн шуурхай гүйцэтгэн баталгаажуулж, нэгдсэн тайланг цаг хугацаанд нь гарган, нэг мемориалаар архивын нэгж баримт болгон хянуулж, баталгаажуулан ажиллаа.

Төрийн сангийн банкны төлбөр, тооцооны ажлаар төлбөр тооцоо хариуцсан мэргэжилтний системд бүртгэсэн гүйлгээг төлбөрийн хүсэлт, хяналтын хуудсыг үндэслэн шалган баталгаажуулах, гүйлгээ залруулахтай холбогдсон залруулгын бичилт, төрийн сан банкны дансдын үлдэгдэл, орлого, зарлагын дансны хуулга, нягтлан бодох журналаар төрийн сангийн өдөр тутмын гүйлгээг тулган шалгаж нэгдсэн тайланг гарган төрийн сангийн мемориалын баримтыг бэлтгэн хэлтсийн даргаар баталгаажуулан архивын нэгж үүсгэх, төрийн санд нээгдсэн дансны хяналтыг хэрэгжүүлэх, зөвшөөрөлгүй нээгдсэн дансдыг хаах, дүүргийн ЗГСУМС-

ийн хэрэглэгчийн болон тэмдгийн бүртгэлийг хөтлөж, холбогдох байгууллагад хүргүүлэх ажлыг зохион байгуулан гүйцэтгэж ажиллаа.

Хүрч буй үр дүн: Төрийн сан банкны өдөр тутмын үйл ажиллагаа тогтмолжиж, хэрэглэгчдэд хөнгөн шуурхай үйлчилж, төлбөр тооцооны үйл ажиллагаа хэвийн, “бага” эрсдэлтэй ажиллаж байна.

1.3 Монгол улсын төсөв, санхүүгийн талаарх хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, сурталчлах, хяналт тавих ажлыг тогтмолжуулан төсвийн сахилга хариуцлага, үр ашиг, тайлагнал, ил тод нээлттэй байдлыг хангана.

1.3.1 Төсөвт байгууллагуудын улирал, жилийн санхүүгийн тайланг хүлээн авах, нэгдсэн тайлан гаргах, нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартыг бүрэн нэвтрүүлэх ажлыг зохион байгуулах.

Хэрэгжилт, биелэлт:

Дүүргийн төсөвтэй харилцагч төсөвт байгууллагуудын 2016 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэлийн санхүүгийн тайлан тэнцлийг хуваарь, удирдамжийн дагуу хянан хүлээн авч баталгаажуулан, Орон нутгийн болон Төсвийн ерөнхийлөн захирагчдын санхүүгийн нэгтгэсэн тайлан тэнцлийг гаргах ажлыг зохион байгуулан, хуулийн хугацаанд Төсвийн гүйцэтгэлийн санхүүгийн Орон нутгийн болон Тусгай зориулалтын шилжүүлгийн нэгтгэсэн санхүүгийн тайланг хуулийн хугацаанд Нийслэлийн Санхүү, төрийн сангийн хэлтэст хүргүүлж ажиллаа.

Төсвийн гүйцэтгэлийн санхүүгийн тайлан тэнцлийг хянан хүлээн авах явцад Нийслэлийн аудит газар, Өмчийн харилцааны газарт Дүүргийн төсвийн гүйцэтгэлийн Орон нутгийн болон Тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүгийн нэгтгэсэн тайлан тэнцлийг илгээх, хянуулах, нэгтгүүлэх, мөн дүүргийн төсөвтэй харилцагч төсөвт байгууллагуудын төсвийн гүйцэтгэлийн санхүүгийн тайлан тэнцлийг хуваарийн дагуу хүргүүлж, аудит хийлгэн, Аудитын дүгнэлт, зөвлөмж гаргуулах ажлуудыг зохион байгуулан ажилласан байна.

Орон нутгийн болон тусгай зориулалтын шилжүүлгийн дүүргийн Төсвийн гүйцэтгэлийн Санхүүгийн нэгтгэсэн тайлан тэнцлийг гаргаж, хуулийн дагуу Нийслэлийн Санхүү, төрийн сангийн хэлтэст хуулийн хугацаанаас нь өмнө хүргүүлж хянуулах ажлыг зохион байгуулж, мөн Нийслэлийн Аудитын газарт өргөн барьж санхүүгийн тайлангийн аудит хийлгэх ажлыг зохион байгуулан ажилласнаар “Санхүүгийн нэгтгэсэн тайланг баталгаажуулах аудит”-ын менежментийн захидлыг Дүүргийн Засаг даргад Нийслэлийн аудитын газраас ирүүлж, Захидлын хариуг хүргүүлэн, нэгтгэсэн санхүүгийн тайлангийн дүгнэлт гаргуулж, “Зөрчилгүй, санал дүгнэлт”-ийг авч ажилласан болно.

Хүрч буй үр дүн: Орон нутгийн болон Тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүгийн нэгтгэсэн тайлан тэнцлийг хуулийн хугацаанд нь гаргах ажил тогтмолжин, “Зөрчилгүй” санал дүгнэлт авч ажилласан.

1.3.2 Дүүргийн аж ахуйн нэгж байгууллагуудын улирал, жилийн санхүүгийн тайланг хүлээн авах, нэгдсэн тайланг гаргах, нягтлан бодох

бүртгэлийн олон улсын стандартыг бүрэн нэвтрүүлэх ажлыг зохион байгуулах.

Хэрэгжилт, биелэлт:

Нягтлан бодох бүртгэлийн тухай шинэчлэн найруулсан хууль, Монгол улсын Сангийн Сайдын 2014 оны 201 дугаар тушаал, 2016 оны 41 дүгээр тушаалуудын дагуу дүүргийн баазад бүртгэлтэй дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй төрийн болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж байгууллагуудын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын болон холбогдох заавар журмын дагуу шалган, илэрсэн зөрчлийг арилгуулан хүлээн авч нэгтгэн, е-балансын программаар баталгаажуулан илгээх ажлыг зохион байгуулан гүйцэтгэж ажиллаа. Санхүүгийн тайлан тэнцэл тушаалвал зохих 10424 аж ахуйн нэгж байгууллагаас тушаасан 8281, тайлан огт ирүүлээгүй 2143 аж ахуйн нэгж байгууллага байна. Тушаасан 8281 аж ахуйн нэгж байгууллагаас хугацаандаа тушаасан 5861 аж ахуйн нэгж, хугацаа хоцроосон 2420 аж ахуйн нэгж байгууллагууд байгаа бөгөөд Санхүүгийн тайлан хүлээн авалт 79.4%-ийн гүйцэтгэлтэй гарсан байна. Тайлангаа хугацаандаа тушаагүй болон НББ-ийн хууль зөрчсөн 10 албан тушаалтан болон байгууллагад 8 064,0 мянган төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч, торгуулийг бүрэн барагдуулан ажиллаж ирлээ.

Тайлант онд Монгол Улсын Сангийн сайдын 2014 оны 201-р тушаалын дагуу дүүргийн төсөвтэй харилцагч 63 төрийн өмчийн болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж байгууллагуудын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд Аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн дүгнэлтээр болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15-р зүйлийн дагуу залруулга хийж ажилласан.

Монгол Улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн дагуу тайлант онд өссөн дүнгээр 12 аж ахуйн нэгж байгууллагад торгуулийн хариуцлага хүлээлгэж, 9120.0 мянган төгрөгийн торгууль ноогдуулан төсвийн орлогод бүрэн төвлөрүүлсэн байна.

Дүүргийн төсөвтэй харилцагч аж ахуйн нэгж байгууллагуудын болон Санхүүгийн зохицуулах хорооны даргын тушаал, тухайн байгууллагуудын хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрүүдийг үндэслэн Банк бус санхүүгийн байгууллагуудын завсрын нийт 57 санхүүгийн тайланг хагас жилийн байдлаар баталгаажуулсан болно.

Дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг Фалька-Экологи ХХК, Төмөр толгой ХХК, Сэт импекс ХХК, Аззүрро ХХК, Мөнххасцамхаг ХХК, Эрдэнэсуврага ХХК, Итгэлт дүүрэн констракшн ХХК, Андлайнс ХХК, Эрдэнийн шаглаа ХХК зэрэг компаниудын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг аудитын компанийн дүгнэлтээр цахим санхүүгийн программд тус тус залруулга хийж ажилсан байна. “Сонк ББСБ” ХХК, Мөнх-Америта ХХК, Дийп сурвей ХХК, “Соломон инвестментс ББСБ” ХХК, Түшиг Өргөө ХХК зэрэг компаниудын засварын тайланг тус тус дахин баталгаажуулсан ба шинээр үүсгэн байгуулагдсан 33 аж ахуйн нэгж байгууллагуудыг цахим санхүүгийн программын байгууллагын бүртгэлд шинээр оруулж бүртгэлээ.

Хүрч буй үр дүн:

Аж ахуйн нэгж, байгууллагуудын санхүүгийн тайлан хуулийн хугацаандаа ирж баталгаажиж, дүн нэгтгэлд орох ажил бүрэн автомажиж цахимжсан.

1.3.3 Төсөв, санхүүгийн ил тод байдлыг хангахад дагаж мөрдөх журмын дагуу дүүргийн цахим хуудас, сурталчилгааны булангаар дамжуулан санхүү, төрийн сангийн үйл ажиллагааг иргэдэд мэдээлэх, Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд төсөвт байгууллагуудын санхүүгийн тайлан, мэдээг олон нийтэд ил тод мэдээлэх ажилд хяналт тавьж ажиллах.

Хэрэгжилт, биелэлт:

Хэлтсийн ажилтан нарын Шилэн дансны тухай хуулийн дагуу оруулах мэдээллүүдийн ажил үүргийн нэгдсэн хуваарийг дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2016 оны А/21 дүгээр тушаалаар баталгаажуулан, Сангийн Яамны болон дүүргийн вэб сайтад мэдээллүүдийг тогтмол оруулан, мэдээллийн ил тод байдлын ханган ажиллаж байна.

Дүүргийн төсөвтэй харилцагч 66 төсөвт байгууллага нь Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтээр холбогдох мэдээллүүдийг Сангийн Яамны нэгдсэн мэдээллийн санд сар бүр гүйцэтгэлүүдийг оруулж, төсөвт байгууллагууд нь өөрийн вэб сайт, мэдээллийн самбартаа холбогдох мэдээллүүдийг оруулан ажиллаж байна.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2, 5 дугаар зүйлийн 5.5, 5.7, 5.8, 6 дугаар зүйлийн 6.1, 6.2, 6.3, 6.4 дэх заалтуудыг хэрэгжүүлэх зорилгоор хэлтсийн ажилтнуудын “Шилэн дансны хууль”-ийг хэрэгжүүлэх ажил үүргийн нэгдсэн хуваарийг Дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2016 оны А/21 тушаалаар батлуулан, хуваарийн дагуу мэдээллийг гаргаж, гүйцэтгэлд хяналт тавин ажиллаж байна.

Мөн Шилэн дансны хуулийг хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэх ажлын хүрээнд дүүргийн Засаг даргын 2016 оны 263-р захирамжийг гаргуулан, үндсэн нэгж, төсвийн шууд захирагч нарт хүргүүлэн хэрэгжилтэд нь хяналт тавьж, ажлын биелэлтийг сар бүр авч, шаардлагатай ажлыг зохион байгуулан ажиллаж ирлээ.

Чингэлтэй дүүргийн “Шилэн дансны мэдээлэл” самбарыг шинэчлэн, шинэчилсэн дүүргийн логог байрлуулж, доторх тоон болон график, диаграммын хүснэгтэн мэдээллийг сар бүр сольж, иргэд, олон нийтэд мэдээллийн ил тод, нээлттэй, ойлгомжтой, хүртээмжтэй мэдээллийн сурталчилгааг ханган ажиллаж байна.

Дүүргийн Засаг даргын 2016 оны А/263 тоот захирамж, Тамгын газрын даргын 2016 оны А/21 тоот тушаалийг хэрэгжүүлэх, хяналт тавих, зохион байгуулах ажлын хүрээнд Санхүү, төрийн сангийн хэлтсийн ажил хариуцсан мэргэжилтэнгүүд, дүүргийн төсөвтэй харилцагч төсөвт байгууллагуудын 66 нягтлан бодогч нар нь цалингаас бусад таван сая төгрөгнөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэрийн хамт гүйлгээ хийснээс хойш 7 хонгийн

дотор цахим хуудсанд байршуулах ажлыг цаг хугацаанд нь тогтмол зохион байгуулан ажиллаж ирлээ.

Дүүргийн Засаг даргын 2016 оны А/263 тоот захирамж, Тамгын газрын даргын 2016 оны А/21 тоот тушаалийг хэрэгжүүлэх, хяналт тавих, зохион байгуулах ажлын хүрээнд Санхүү, төрийн сангийн хэлтсийн ажил хариуцсан мэргэжилтэнүүд, дүүргийн төсөвтэй харилцагч төсөвт байгууллагуудын 66 нягтлан бодогч нар нь таван сая төгрөгнөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаягийг дүүргийн болон тухайн байгууллагуудын цахим хуудас, сурталчилгааны самбарт байршуулах ажлыг хуулийн хугацаанд нь тогтмол хэрэгжүүлэн ажиллаж ирсэн байна.

Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд дүүргийн Засаг даргын 2016 оны А/263 тоот захирамж, Тамгын газрын даргын 2016 оны А/21 тоот тушаалийг шинэчлэн гаргаж, шилэн дансны 24 мэдээллийг гаргах албан тушаалтан, хугацааг захирамж, тушаалын хавсралтаар баталгаажуулан хэлбэржүүлж, хэрэгжүүлэн, хэрэгжилтэнд нь хяналт тавьж, шаардлагатай ажлыг зохион байгуулах ажлыг санхүү, төрийн сангийн хэлтсийн ажил хариуцсан ажилтангууд болон дүүргийн төсөвтэй харилцагч төсөвт 66 байгууллагын нягтлан бодогч нар гүйцэтгэн дүүргийн болон төсөвт байгууллагын цахим хуудас, мэдээллийн самбарт байрлуулан ажиллаж байна.

Хүрч буй үр дүн: Санхүү, төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлийн ажлууд иргэд, аж ахуйн нэгжид ил тод, хүртээмжтэй мэдээлэгдэх боломж нээгдэж, биелэлээ олж байгаа ба батлагдсан хууль, журам, заавруудын хүрээнд хэрэгжиж байна.

Санхүү, төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлийн ажлууд иргэд, аж ахуйн нэгжид ил тод, ойлгомжтой, хүртээмжтэй мэдээлэгдэх боломж нээгдэж, биелэлээ олж байна.

1.3.4 Төсөвт байгууллагуудын нягтлан бодогч нарын ажлыг хагас бүтэн жилээр дүгнэх.

Хэрэгжилт, биелэлт:

Дүүргийн төсөвтэй харилцагч 66 төсөвт байгууллагуудын нягтлан бодогч нарын 2016 оны жилийн эцсийн ажлыг Монгол улсын Сангийн сайдын 2006 оны 292-р тушаалын батлагдсан үзүүлэлтийн дагуу дүгнэж, ажлаараа дээд оноо авсан төсөвт байгууллагуудын нягтдан бодогч нарт дүүргийн Засаг дарга буюу төсвийн ерөнхийлөн захирагчийн 2017 оны А/294 дүгээр захирамжийг үндэслэн хэлтсийн даргын 2017 оны 4/900 тоот албан бичгээр орон нутгийн болон тусгай зориулалтын төсөвт байгууллагуудын 49 нягтлан бодогчид урамшуулал олгох эрхийг олгож, олон жил тогтвор сууршилтай, үр бүтээлтэй ажиллаж байгаа дүүргийн төсөвт байгууллагын 43 нягтлан бодогч нарыг дүүргийн 25 жилийн ойн медалиар шагнаж урамшуулан, нягтлан бодогч нарын нэгдсэн зөвлөгөөнийг зохион байгуулан ажиллаа.

Хүрч буй үр дүн: Төсөвт байгууллагуудын нягтлан бодогч нарын ур чадвар сайжирч, тогтвор суурьшилтай, бүтээлчээр үр дүнтэй ажиллах эхлэл тавигдсан.

1.3.5 ББСБ, Даатгал, ХЗХ, дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлдэг хувьцаат компаниудын холбогдох мэлээллүүдийг тогтмол хугацаанд Санхүүгийн Зохицуулах Хороонд хүргүүлэх.

Хэрэгжилт, биелэлт:

Дүүргийн төсөвтэй харилцагч аж ахуйн нэгж байгууллагуудын болон Санхүүгийн зохицуулах хорооны даргын тушаал, тухайн байгууллагуудын хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрүүдийг үндэслэн Банк бус санхүүгийн байгууллагуудын завсрын нийт 57 санхүүгийн тайланг хагас жилийн байдлаар баталгаажуулсан болно.

Хүрч буй үр дүн: СЗХорооны орон нутгийн төлөөлөгчийн орон тооны бус ажил гэрээний дагуу хийгдэж, ажил нь тогтмолжсон.

1.3.6 Дүүргийн төсөвтэй харилцагч сургууль, цэцэрлэгүүдэд удирдамжийн дагуу шалгалт, шалган зааварчилах ажиллагааг гүйцэтгэх.

Хэрэгжилт, биелэлт:

Дүүргийн төсөвтэй харилцагч орон нутгийн болон тусгай зориулалтын шилжүүлгийн төсөвт байгууллагуудад зөвлөн туслах, зааварчлах, мэргэжил арга зүйгээр хангах 2017 оны нэгдсэн удирдамж, хуваарийг хийж хэлтсийн даргаар батлуулснаар улс, нийслэл, дүүргийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрээр нэмэлт бүлгийн шинээр ашиглалтанд орсон 7 сургууль, цэцэрлэгүүдийн бүртгэл тооцооны болон үйл ажиллагааны явцад зөвлөн туслах, зааварчлах, мэргэжил арга зүйгээр хангах, үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгч, ажлын зааварчлах хуудсаар тодорхой үүрэг даалгавар өгөх ажлыг зохион байгуулж, гүйцэтгэн ажиллаж ирлээ.

Хүрч буй үр дүн: Удирдамж, хуваарийн дагуу цаг хугацаандаа бүрэн хийгдэж, мэргэжлийн арга зүй, зааварчилгаагаар хангагддаг болсон.

1.4 Дүүргийн өмч хөрөнгийн менежментийг сайжруулан, үр ашгийг нэмэгдүүлнэ.

1.4.1 Орон нутгийн өмчийн эзэмшилт, ашиглалтыг сайжруулж, эд хөрөнгийн үзлэг тооллогыг явуулж, Нийслэлийн өмчийн харилцааны газар болон үл хөдлөх хөрөнгийн эрхийн Улсын бүртгэлд бүрэн хамруулна.

Хэрэгжилт, биелэлт:

Дүүргийн төсөвтэй харилцагч Орон нутгийн болон Тусгай зориулалтын шилжүүлгийн төсөвт байгууллагуудын өмч ашиглалтын 2016 оны гэрээг дүгнэх, 2017 оны гэрээг байгуулах ажлыг 67 нэгжид зохион байгуулан гүйцэтгэж, гэрээг баталгаажуулан өмч хөрөнгөнд бүртгэлээр тавих хяналтыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Дүүргийн нийтийн эзэмшлийн өмч хөрөнгийн тооллогыг зохион байгуулж, үр дүнг данс бүртгэл тусган, тооллогын талаарх дэлгэрэнгүй танилцуулгыг боловсруулан дүүргийн удирдлагуудад танилцуулан ажиллахын зэрэгцээ хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөрөөр хийгдсэн хөрөнгийг данс бүртгэлд авах, эзэнжүүлэх асуудлыг НӨХГ-т тавьж, зөвшөөрлийн дагуу бүрэн шийдвэрлэн ажиллаж, ашиглалтанд нь бүртгэлээр хяналт тавин ажиллаж ирлээ.

Дүүргийн нийтийн эзэмшлийн болон орон нутгийн өмчийн 2017 оны эхний хагас жилийн тооллогыг зохион байгуулах ЗДТГ-ын даргын тушаалаар "Ажлын хэсэг" байгуулж, өмч хөрөнгийг нэг бүрчлэн тоолох, бүртгэх, бусад шаардлагатай ажлуудыг зохион байгуулан ажилласнаар хөрөнгийг нэг бүрчлэн үзэж тоолох, бүртгэл хөтлөх ажлуудыг дуусгасан болно. Хөрөнгийг нэгтгэх, дүн мэдээ гаргах, танилцуулга боловсруулах, үр дүнг зохих шатны удирдлагуудад танилцуулж, зохих ажлуудыг гүйцэтгэсэн байна.

Ашиглалтад хүлээн авсан хөрөнгө, ажил үйлчилгээг данс бүртгэлд бүртгэх дүүргийн Засаг даргын захриамж гаргуулан, Нийслэлийн өмчийн харилцааны газар болон үл хөдлөх хөрөнгийн эрхийн Улсын бүртгэлд хамруулах бэлтгэл зохион байгуулалтын ажлыг гүйцэтгэж байна.

2016 оны Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэж, ашиглалтад хүлээн авсан өмч хөрөнгийг "Хөрөнгө бүртгэх тухай" Засаг даргын Тамгын газрын даргын 2016 оны А/47дугаар захирамжийг гарган, данс бүртгэлд бүртгэх ажлыг зохион байгуулж, Нийслэлийн өмчийн харилцааны газар болон үл хөдлөх хөрөнгийн эрхийн Улсын бүртгэлд хамруулах ажлыг зохион байгууллаа.

Хүрч буй үр дүн: Орон нутгийн эзэмшлийн өмч хөрөнгийн ашиглалт, эзэмшилт, хадгалалт хамгаалалтанд бүртгэлээр хяналт тавин ажиллаж байна.

1.4.2 Орон нутгийн өмчийн байгууллагуудтай өмч эзэмшүүлэх гэрээг хийж, байгууллагын өмч хамгааллын байнгын комиссын ажлыг эрчимжүүлнэ.

Хэрэгжилт, биелэлт:

Дүүргийн орон нутгийн төсөвт байгууллагуудтай орон нутгийн өмчийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтын талаар өмч ашиглалтын гэрээг НӨХГазартай хийлгэх, хөрөнгийн ашиглалт, хадгалалт хамгаалалт, эзэмшилтийн байдалд бүртгэлээр хяналт тавих ажлыг зохион байгуулан гүйцэтгэсэн.

Дүүргийн төсөвтэй харилцагч Орон нутгийн болон Тусгай зориулалтын шилжүүлгийн төсөвт байгууллагуудын өмч ашиглалтын 2016 оны гэрээг дүгнэх, 2017 оны гэрээг байгуулах ажлыг 67 нэгжид зохион байгуулан гүйцэтгэж, гэрээг баталгаажуулан өмч хөрөнгөнд бүртгэлээр тавих хяналтыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Дүүргийн нийтийн эзэмшлийн өмч хөрөнгийн тооллогыг зохион байгуулж, үр дүнг данс бүртгэл тусган, тооллогын талаарх дэлгэрэнгүй танилцуулгыг боловсруулан дүүргийн удирдлагуудад танилцуулан ажиллахын зэрэгцээ

хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөрөөр хийгдсэн хөрөнгийг данс бүртгэлд авах, эзэнжүүлэх асуудлыг НӨХГ-т тавьж, зөвшөөрлийн дагуу бүрэн шийдвэрлэн ажиллаж, ашиглалтанд нь бүртгэлээр хяналт тавин ажиллаж ирлээ.

Дүүргийн нийтийн эзэмшлийн болон орон нутгийн өмчийн 2017 оны эхний хагас жилийн тооллогыг зохион байгуулах ЗДТГ-ын даргын тушаалаар "Ажлын хэсэг" байгуулж, өмч хөрөнгийг нэг бүрчлэн тоолох, бүртгэх, бусад шаардлагатай ажлуудыг зохион байгуулан ажилласнаар хөрөнгийг нэг бүрчлэн үзэж тоолох, бүртгэл хөтлөх ажлуудыг дуусгасан болно. Хөрөнгийг нэгтгэх, дүн мэдээ гаргах, танилуулга боловсруулах, үр дүнг зохих шатны удирдлагуудад танилцуулахаар зохих ажлуудыг гүйцэтгэж байна.

Ашиглалтад хүлээн авсан хөрөнгө, ажил үйлчилгээг данс бүртгэлд бүртгэх дүүргийн Засаг даргын захриамж гаргуулан, Нийслэлийн өмчийн харилцааны газар болон үл хөдлөх хөрөнгийн эрхийн Улсын бүртгэлд хамруулах бэлтгэл зохион байгуулалтын ажлыг гүйцэтгэж байна.

2016 оны Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэж, ашиглалтад хүлээн авсан өмч хөрөнгийг "Хөрөнгө бүртгэх тухай" Засаг даргын Тамгын газрын даргын 2016 оны А/47 дугаар захирамжийг гарган, данс бүртгэлд бүртгэх ажлыг зохион байгуулж, Нийслэлийн өмчийн харилцааны газар болон үл хөдлөх хөрөнгийн эрхийн Улсын бүртгэлд хамруулах ажлыг зохион байгууллаа.

Хүрч буй үр дүн: Орон нутгийн өмч хөрөнгийн ашиглалт, хадгалалт хамгаалалт, эзэмшилтийн байдалд бүртгэлээр хяналт тавигдаж, үр дүн, биелэлтийг дүүргийн ИТХ-ын Тэргүүлэгчдээр хэлэлцүүлэн ажлын чиглэл авч ажилладаг болсон байна.

1.4.3 Сангийн сайдын 2012 оны 260-р тушаалын 2-р хавсралтыг хэрэгжүүлэн торгууль, шийтгэврийн хуудасны тооцоог хийж, тайланг Сангийн яаманд хүргүүлэх.

Хэрэгжилт, биелэл:

2016 оны жилийн эцсийн торгууль, шийтгэврийн хуудасны зарцуулалтын тайланг гарган, хэлтсийн даргаар баталгаажуулан Сангийн яаманд 2017 оны 01-р сарын 08-нд хүргүүлж, тооцоо нийлсэн актаар баталгаажуулсан.

Монгол Улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн дагуу тайлант онд өссөн дүнгээр 12 аж ахуйн нэгж байгууллагад торгуулийн хариуцлага хүлээлгэж, 9120.0 мянган төгрөгийн торгууль ноогдуулан төсвийн орлогод бүрэн төвлөрүүлсэн байна.

Хүрч буй үр дүн: Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг биелүүлэхэд орлогын эх үүсврийг нэмэгдүүлж, хуулийн хэрэгжилтийг ханган ажилласан.

1.5 Дүүргийн хэмжээнд хийгдэх хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэлд хяналт тавьж, санхүүжүүлэх ажлыг зохион байгуулна.

1.5.1 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэлийн явцад хяналт тавьж, хөрөнгө оруулалтын арга хэмжээний дүн мэдээллийг нэгтгэн дүгнэлт хийж, удирдлагыг мэдээллээр ханган, дээд байгууллагад мэдээлэн ажиллах.

Хэрэгжилт, биелэлт:

Дүүргийн орон төсвийн хөрөнгө оруулалтаар 2017 онд хэрэгжүүлэх 28 төсөл, арга хэмжээнүүд 100% хийгдэж дууссан ба нийт гүйцэтгэлээр 1 тэр бум 995.0 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Орон нутгийн сангийн хөрөнгөөр хэрэгжих 25 төсөл арга хэмжээ 100% хийгдэж дууссан ба нийт ажлын гүйцэтгэлээр 251 сая 049 мянган төгрөгийн санхүүжилт олгогдсон.

Төсвийн тодотголоор 42 арга хэмжээ хэрэгжихээс 25 ажил 100% хийгдэж дууссан ба гэрээ байгуулах ажил дууссан 85, гэрээ байгуулах шатандаа 1, тендерийн үнэлгээ хийгдэж буй 3, гүйцэтгэлээрх явцтай ажлууд 14, тендер зарлах шатандаа 6 ажлууд тус тус байна. Нийт ажлын гүйцэтгэлээр 2 тэр бум 635.0 сая төгрөгийн санхүүжилт олгогдсон байна.

Хүрч буй үр дүн: Батлагдсан төсвийн хүрээнд худалдан авах ажиллагаа хуулийн хүрээнд зохион байгуулагдаж, бодит үр дүн нь урьд оныхоос дээшилсэн байна.

1.5.2 Улс, Нийслэл, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжигдэх ажлын гүйцэтгэлийг хянан баталгаажуулж, ирүүлсэн гүйцэтгэлийг үндэслэн Нийслэлийн Санхүү, төрийн сангийн хэлтэст албажуулан хүргүүлж, санхүүжилтийн эрхийг нээлгэх.

Хэрэгжилт, биелэлт:

12-р хороо Жишиг ӨЭМТ-д рентген аппарат авах 392.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлын гэрээ байгуулагдсан, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний нэн шаардлагатай тоног төхөөрөмж бага хэрэгсэл худалдан авах 200.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажил гэрээ байгуулах шатандаа, ерөнхий боловсролын сургуулиудын хөдөлмөрийн кабининетад шаардлагатай тоног төхөөрөмж нийлүүлэх 158.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажил 100%-ийн гүйцэтгэлтэй бүрэн дууссан, 70-р цэцэрлэгийн нэмэлт бүлгийн өргөтгөлийн 150.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажил 30%-ийн гүйцэтгэлтэй, 126-р цэцэрлэгийн нэмэлт бүлгийн өргөтгөлийн 278.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажил 30%-ийн гүйцэтгэлтэй, 72-р сургуулийн “Урлаг заал”-ны засварын 48.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажил 100%-ийн гүйцэтгэлтэй бүрэн дууссан, хамдаа хөгье хөтөлбөрийн хүрээнд ажлын байр бий болгох 283.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажил гэрээ байгуулах шатандаа, хамтдаа хөгжье хөтөлбөрийн хүрээнд жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн тоног төхөөрөмж технологийг сайжруулах 105.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажил тендер зарлах шатандаа, 7-р хороо эрх зүйн туслалцааны Самбалхүндэвийн эргэмжийн газар хүртэлх авто замын 205.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажил тендер зарлагдсан, гэр хорооллын айл өрхүүдийн цахилгаан хангамжийг сайжруулах, гэр хорооллын гэрэлтүүлэгийг шинэчлэн сайжруулах 200.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажил тендер зарлах бэлтгэл ажил хийгдэж байгаа, орчин үеийн дэвшилтэт технологи бүхий нарны

зайн хураагуур бүхий эко гэрэлтүүлэгийн 100.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлын гэрээ байгуулагдсан, цагдаагийн 1-р хэлтсийн гадна тохижилтын техник тоног төхөөрөмж нийлүүлэх 50.0 сая төгөгийн төсөвт өртөгтэй ажлын бэтгэл хангагдаж байгаа, 2-р хэлтсийн материаллаг баазыг бэхжүүлэх техник тоног төхөөрөмж нийлүүлэх 29.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажил бэлтгэл ажил хийгдэж байгаа, замын цагдаагийн материаллаг баазыг бэхжүүлэх техник тоног төхөөрөмж нийлүүлэх 36.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажил 85%-ийн гүйцэтгэлтэй, замын цагдаагийн хэлтсийн үүдний хэсгийн засварын 10.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлын тендер зарлагдсан, мэргэжлийн хяналтын хэлтэст тоног төхөөрөмж нийлүүлэх 29.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажил 100% гүйцэтгэлтэй бүрэн дууссан, татварын хэлтсийн түрээсийн байрны засварын 29.9 сая төгрөгийн ажил 100%-ийн гүйцэтгэлтэй бүрэн дууссан, татварын хэлтсийн улсын байцаагчдын тавилга, тоног төхөөрөмж нийлүүлэх 19.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажил 85%-тай, ОУБ,Иргэд, ААНБ,ТББ-уудтай хамтын ажиллагаа хэрэгжүүлэх орон нутгийн оролцооны 50.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажил гэрээ байгуулагдсан, зураг төсвийн зардлын 100.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажил бэлтгэл ажил хийгдэж байгаа, магадлашгүй ажлын зардал 50.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажил бэлтгэл ажил хийгдэж байгаа зэргийн тус тус гүйцэтгэлтэй байна.

“Хоовжий” ХХК-ийн гүйцэтгэсэн 2 дугаар хорооны 23 дугаар байрны дээвэр засварын ажлыг 2017 оны 10 дугаар сарын 17-ны өдөр, “Зорь бүтээ” ХХК-ийн гүйцэтгэсэн 3 дугаар хорооны 40 мянгатын 17 дугаар байрны гадна талбайн тохижилтын ажлыг 2017 оны 10 дугаар хорооны 18-ны өдөр, “Халиун проперти” ХХК-ийн гүйцэтгэсэн Чингэлтэй дүүргийн Цагдаагийн 1 дүгээр хэлтэст шаардлагатай техник хэрэгсэл нийлүүлэх 33 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлыг 2017 оны 10 дугаар сарын 25-ны өдөр, “Хамтын хүч” Иргэдийн бүлгийн гүйцэтгэсэн Чингэлтэй дүүргийн 17 дугаар хорооны цогцолбор байрны гадна талбайн тохижилтын 18,9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлыг 2017 оны 10 дугаар сарын 30-ны өдөр, “Аривжин дэлгэрэх” ХХК-ийн гүйцэтгэсэн 18 дугаар хороо Яргайтын 19, 22 дугаар гудамжинд явган зам тавих 7,9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлыг 2017 оны 10 дугаар сарын 30-ны өдөр, “Энэрэлт Их Эрдэнэ” ХХК-ийн гүйцэтгэсэн 1 дүгээр хорооны 50 дугаар байрны фасадны дулаалга засварын ажлыг 2017 оны 10 дугаар сарын 31-ны өдөр, “Экспресс зам” ХХК-ийн гүйцэтгэсэн Чингэлтэй Хайрхан уул орчмын тохижилт, ойг нөхөн сэргээх ажлын хүрээнд хийгдэх байгалын чулуун хийц бүхий тохижилтын 499,7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлыг 2017 оны 11 дүгээр сарын 03-ны өдөр, “Тохилог-41” Иргэдийн бүлгийн гүйцэтгэсэн Чингэлтэй дүүргийн 6 дугаар хороо, 39А байрны гадна талбайн тохижилтын 19,4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлыг 2017 оны 11 дүгээр сарын 06-ны өдөр, “Зорголконстракшн” ХХК-ийн гүйцэтгэсэн Чингэлтэй дүүргийн 9 дүгээр хороо тоглоомын талбайн тохижилтын 68,5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлыг 2017 оны 11 дүгээр сарын 09-ны өдөр, “Квадровэй” ХХК-ийн гүйцэтгэсэн 5 дугаар хорооны 18 дугаар байрны урдах тохижилтын ажлыг 2017 оны 11 дүгээр сарын 09-ны өдөр, “Шахайт ундарга” ХХК-ийн хийж гүйцэтгэсэн 19 дүгээр хороо Ар согоотод зөөврийн ус түгээх байр барих ажлыг 2017 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр, “Би би экс эл” ХХК-ийн гүйцэтгэсэн Цагдаагийн 1 дүгээр хэлтсийн гадна талбайд мэдээллийн гэрэлт самбар байгуулах ажлыг 2017 оны 11 дүгээр сарын 18-ны өдөр,

“Эволва” ХХК-ийн гүйцэтгэсэн 10 дугаар хорооны хүүхдийн тоглоомын талбайн тохижилтын ажлыг 2017 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр, “Топ дрийлинг” ХХК-ийн гүйцэтгэсэн 18 дугаар хорооны 43 дугаар гудамжинд гүний худаг барих ажлыг 2017 оны 11 дүгээр сарын 27-ны өдөр, “Эв нэгдэл” Иргэдийн бүлгийн гүйцэтгэсэн 18 дугаар хороо, Яргайтын 38 дугаар гудамжинд явган зам тавих ажлыг 2017 оны 11 дүгээр сарын 27-ны өдөр, “Даймондтопаз” ХХК-ийн хийж гүйцэтгэсэн 17 дугаар хорооны Зүрх уулын 3 дугаар гудамжинд гүний худаг барих ажлыг 2017 оны 11 дүгээр сарын 27-ны өдөр, “Шинь хөн” ХХК-ийн хийж гүйцэтгэсэн 16 дугаар хороонд гүний худаг барих ажлыг 2017 оны 11 дүгээр сарын 27-ны өдөр, “Соёндрийм” ХХК-ийн гүйцэтгэсэн 4,6,7,8,9,10,11 дүгээр хороонд хийгдэж буй гэр хорооллын гудамжны гэрэлтүүлэг хийх ажлыг 2017 оны 11 дүгээр хорооны 28-ны өдөр, “Бодь хангай “ ХХК-ийн гүйцэтгэсэн Чингэлтэй хайрхан уулын орчим Улсын тусгай хамгаалалтын хашаажуулалтын ажлыг 2017 оны 12 дугаар сарын 04-ны өдөр, “Тольт хөдөлгүүр” ХХК-ийн гүйцэтгэсэн Цагдаагийн 2 дугаар хэлтсийн материаллаг баазыг бэхжүүлэх, техник тоног төхөөрөмжөөр хангах ажлыг 2017 оны 12 дугаар сарын 06-ны өдөр тус тус хүлээн авч, орон нутгийн өмчид бүртгэх, гүйцэтгэл тоо хэмжээг хянан шалгаж холбогдох материалыг үндэслэн гэрээг дүгнэн ажиллалаа.

Хүрч буй үр дүн: Батлагдсан төсвийн хүрээнд улс, нийслэл, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх хөрөнгө оруулалтын ажил хуулийн хүрээнд зохион байгуулагдан, иргэд, олон нийтэд хүрэх хүртээмж, үр дүн нь бодит байдалд хүрч, төлөвлөсөн хэмжээнд бүрэн хэрэгжсэн.

1.6 Байгууллагуудын бүртгэл санхүүгийн ажилтнуудад төсөв, санхүү, удирдлага, нягтлан бодох бүртгэлийн чиглэлээр сургалт зохион байгуулах.

Хэрэгжилт, биелэлт:

Дүүргийн төсөвтэй харилцагч төсвийн байгууллага болон дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж байгууллагын нягтлан бодогч, санхүү бүртгэлийн ажилтан нарт хийгдэх хэлтсийн сургалтын 2017 оны нэгдсэн төлөвлөгөөг боловсруулан батлуулж, үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд бэлэн болгосон байна.

Монгол улсын Сангийн Яамны Төрийн сангийн газар, Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс хамтран ЗГУНСистем, Төрийн сангийн нэгдсэн дансны тогтолцооны шинэчлэлийн ажлын хүрээнд “Засгийн газрын санхүүгийн тайлан”- г хүлээн авах, онлайнаар илгээх, тушаах, нэгтгэх, баталгаажуулах, Төсөвт байгууллагын санхүүгийн “Э-ТАЙЛАН”-гийн шинэ программаар 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг гаргах талаарх болон программын агуулгаарх дэлгэрэнгүй сургалтыг 2017 оны 01-р сарын 26-ний өдрийн 10.00 цагт дүүргийн Засаг даргын Тамгын газрын “Хурлын танхим”-д зохион байгууллаа.

Сургалтанд Сангийн Яамны Төрийн сангийн газрын мэргэжилтэн Л.Эрдэнэбадрах, Санхүүгийн программ хангамжийн “Санхүүгийн тооцоолох групп”-ийн нэвтрүүлэлтийн ажилтан Б.Булганчимэг, Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн Ерөнхий нягтлан бодогч Н.Дэлгэрмаа, ТМССХариуцсан мэргэжилтэн Л.Батзориг, Орон нутгийн болон

тусгай зориулалтын шилжүүлэгийн 67 төсөвт байгууллагуудын 50 нягтлан бодогч нар тус тус оролцлоо.

Сургалтыг хөтөлбөр, программын дагуу Төсөвт байгууллагын санхүүгийн аудитлагдсан тайланг Монгол улсын Сангийн Яамны Төрийн сангийн нэгдсэн дансны тогтолцооны “Э-ТАЙЛАН” сайтад онлойнаар шивж илгээх, хянуулах, баталгаажуулах үйл ажиллагааг хийх нэгдсэн заавар журам, санхүүгийн тайлангийн “Aculous” программд орсон өөрчлөлтийг сэргээх, цаашид анхаарах асуудлуудыг дэлгэрэнгүй хэлэлцэж, санал, дүгнэлтээ солилцож ажиллаа.

Дүүргийн төсөвтэй харилцагч орон нутгийн болон тусгай зориулалтын шилжүүлгийн төсөвт байгууллагуудын нягтлан бодогч нарын 2017 оны нэгдсэн зөвлөгөөнийг удирдамж, хөтөлбөрийн дагуу 2017 оны 5-р сарын 19-ны өдөр “Бишрэлт-холдинг” ХХК-ны байранд зохион байгуулан гүйцэтгэлээ.

Нэгдсэн зөвлөгөөнд дүүргийн Засаг дарга Ж.Эрдэнэбат, Засаг даргын Тамгын газрын дарга А.Дамцагдорж, Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга Ж.Орхонбаяр, Дотоод аудитын албаны дарга Ц.Жаргалтай, Санхүү, төрийн сангийн хэлтсийн мэргэжилтэнүүд, төсөвт 67 байгууллагуудын нягтлан бодогч нар тус тус оролцлоо.

Нэгдсэн зөвлөгөөнөөр “Дүүргийн 2016 оны Орон нутгийн болон тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүгийн нэгтгэсэн тайланд санхүүгийн тайлангийн аудит хийж, аудитаас гарсан дүгнэлт, зөвлөмж, тайланд дурдагдсан зөрчил, дутагдалыг арилгах арга зам, зөвлөмжийг хэрэгжүүлэхэд зохион байгуулах ажлын чиглэл, түүний үр дүн”-гийн талаар, “Дотоод аудитын төсвийн байгууллагад 2016 онд хийсэн шалгалтын ажлын үр дүн, цаашидын чиг хандлага”-ын талаар, “2016 онд зохион байгуулсан сургалт, зөвлөн туслах, мэргэжил арга зүйгээр хангах, шалган зааварчлах ажил, мэдээ судалгаа авалтын ажлын үр дүн, цаашид анхаарах асуудал”-ын талаар тус тус хэлэлцлээ.

Зөвлөгөөнд дүүргийн Засаг дарга Ж.Эрдэнэбат, Засаг даргын Тамгын газрын дарга А.Дамцагдорж нар дүүргээс 25 жилийн ой угтаж хийж буй бүтээлч ажил, цаашид хэрэгжүүлэх ажлын талаар дэлгэрэнгүй үг хэлж, олон жил үр бүтээлтэй ажилласан нягтлан бодогч нарт дүүргийн 25 жилийн ойн медаль гардуулсан нь Санхүү, бүртгэл тооцооны ажилтны цаашид ажиллах урам зоригийг сэргээсэн сайхан үйл явдал болж өндөрлөлөө.

Дүүргийн төсөвтэй харилцагч Орон нутгийн болон тусгай зориулалтын шилжүүлгийн 56 төсөвт байгууллагуудын 54 нягтлан бодогч нарын ээлжит семинарыг 2017 оны 9 дгээр сарын 12-ны өдрийн 14 цагт дүүргийн Засаг даргын Тамгын газрын “Хурлын танхим”-д зохион байгууллаа. Ээлжит семинарт Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга Ж.Орхонбаяр, төсвийн мэргэжилтэн Д.Даваадолгор, ерөнхий нягтлан бодогч Н.Дэлгэрмаа, санхүүжилтийн эрх хариуцсан мэргэжилтэн Ж.Мөнхбаяр, ТМСХариуцсан мэргэжилтэн Л.Батзориг, төсөвт байгууллагуудын нягтлан бодогч нар оролцлоо.

Ээлжит семинараар “Дүүргийн орон нутгийн болон тусгай зориулалтын шилжүүлгийн төсөвт байгууллагуудын санхүү, төсвийн үйл ажиллагаанд 2017 оны төлөвлөгөөт явцын болон гүйцэтгэлийн аудитыг Нийслэлийн аудитын газраас хийхтэй холбогдуулан бэлтгэл ажил, анхаарах асуудал”-уудын талаар, “Төсвийн гүйцэтгэлийн эхний 8 сарын явц, цаашдын хандлага, төсөв зардлыг

хямдруулах чиглэл, төсвийн шууд зардлын өр, авлагагүй ажиллах, бэлтгэгдсэн хөрөнгийг данс бүртгэл тусгах асуудал"-уудаар, "Төсөвт тодотгол хийсэнтэй холбогдуулан батлагдсан хуваарийн дагуу санхүүжилтийн эрх хянах, үргүй зардлыг бууруулах, санхүүжилтийн үр өгөөжийг дээшлүүлэх тал"-аар, "Шилэн дансны хуулийн хэрэгжилт, түүний үр дүн, анхаарах асуудал, мэдээний тодруулга боловсруулалт, нягтлан бодогчийн эрх, үүрэг, хариуцлагын тогтолцоог сайжруулах, цаашдын чиг хандлага"-ын талаар, "Дүүрэг үүсч байгуулагдсны 25 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын талаархи" асуудлуудыг тус тус танилцуулан хэлэлцүүлж, санал бодлоо солилцон, тодорхой үүрэг даалгаварыг өгч, мэргэжил арга зүйгээр хангах ажлыг зохион байгуулсан байна.

Нийслэл дэхь Төрийн аудитын газартай хамтран зохион байгуулах дүүргийн орон нутгийн болон тусгай зориулалтын шилжүүлгийн төсөвт байгууллагуудад 2017 оны явцын болон гүйцэтгэлийн аудит хийх нээлтийн ажиллагаа, сургалт-семинарыг 2017 оны 9-р сарын 20-ны өдрийн 10.00 цагт дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг "Тахь-Ко" ХК-ны "ANCORE" сургалтын төвийн зааланд зохион байгууллаа. Нээлтийн үйл ажиллагаа болон сургалт-семинарт: Дүүргийн Засаг дарга бөгөөд Төсвийн ерөнхийлөн захирагч Ж.Эрдэнэбат, Нийслэл дэхь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор С.Энхбаатар, Санхүүгийн 1-р хэлтсийн дарга бөгөөд Аудитын менежер Д.Отгонбаяр, ахлах аудитор А.Цогбаяр, аудитор Ц.Саранцэцэг, И.Эрдэнэцэцэг, Санхүү, төрийн сангийн хэлтсийн мэргэжилтэнүүд, төсөвт 67 байгууллагуудын төсвийн шууд захирагч, нягтлан бодогч нар оролцлоо.

Дүүргийн Засаг дарга бөгөөд Төсвийн ерөнхийлөн захирагч Ж.Эрдэнэбат үйл ажиллагааг нээж, дүүргийн нэгтгэсэн санхүүгийн тайлангийн дүгнэлт, гарсан зөрчил дутагдлын явц байдал, бүртгэл, санхүүгийн хууль тогтоомж, заавар, журмын хэрэгжилтийг хангах, анхан шатны бүртгэл хөтлөлт, цаашид анхаарах асуудлаар үг хэлж, үүрэг даалгавар, зөвлөгөө, чиглэл өгч, санал бодлоо илэрхийллээ.

Мөн Төрийн аудитын байгууллагын шинэчлэл, цаашидын ажлын чиг үүргийн талаар Нийслэл дэхь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор С.Энхбаатар үг хэлж, Санхүүгийн 1-р хэлтсийн дарга бөгөөд аудитын менежер А.Цогбаяр 2016 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн дүгнэлт, зөвлөмжөөр гарсан зөрчил дутагдал, түүний арилгах арга зам, цаашид анхаарах асуудал, явцын болон гүйцэтгэлийн аудитын удирдамж, хөтөлбөр, үйл ажиллагааг зохион байгуулж хэрэгжүүлэх талаар дэлгэрэнгүй мэдээлэл хийж, арга зүй зөвлөмжөөр хангах ажлыг зохион байгуулсан байна.

Дүүргийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсээс Монгол улсын Сангийн Яамны Төсвийн бодлого зохицуулалт, төлөвлөлтийн газартай хамтран дүүргийн орон нутгийн болон тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын нягтлан бодогч нарт 2017 оны 9 дүгээр сарын 27-ны өдөр "2018 оны төсвийн төлөвлөлт, тухайн жилийн төсвийн хүлээгдэж буй гүйцэтгэлийг "Төсвийн төлөвлөлтийн мэдээллийн нэгдсэн систем"-ийг ашиглан гүйцэтгэх тухай нэгдсэн сургалтыг зохион байгууллаа.

Уг сургалтанд Монгол улсын Сангийн яамны Төсвийн бодлого зохицуулалт, төлөвлөлтийн газрын Төслийн зөвлөх Д.Долоонжин, н.Бүжинлхам, Санхүү, төрийн сангийн хэлтсийн төсвийн мэргэжилтэн Б.Даваадолгор, ерөнхий нягтлан бодогч Н.Дэлгэрмаа, төсвийн байгууллагуудын нягтлан бодогч нар оролцлоо.

Сургалтын гол агуулга нь Монгол улсын 2018 оны болон 2018-2020 оны төсвийн төслийн төлөвлөлт, тухайн жилийн ажлын урсгал, төсвийн төлөвлөлт, хуваарилалт, хяналт тавих, түүнд орох өөрчлөлтүүдийн мэдээллүүдийг “Төсвийн төлөвлөлтийн нэгдсэн систем”-д оруулж нэвтрүүлэх тухай мэдлэг олгох, чадавхийг бэхжүүлэхэд чиглэсэн ба хэтийн болон тухайн төсвийн жилийн ажлын урсгалыг системд хэрхэн гүйцэтгэх, ашиглах тухай ойлголтыг өгснөөрөө ач холбогдолтой боллоо.

Монгол улсад хэрэгжиж буй “Төсвийн төлөвлөлтийн мэдээллийн нэгдсэн систем BPIS”-ийг Канад улсын При-баланс Компанийн тусламжтайгаар 2009 оноос эхлэн туршилтийн журмаар хэрэгжүүлж байгаа бөгөөд цг төслийг улс, нийслэл, аймаг, сум, дүүргийн хэмжээнд бүрэн нэвтрүүлж, хэрэгжүүлэхээр ажиллаж байгаа юм.

Чингэлтэй дүүргийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон төсвийн гүйцэтгэлийн нэгтгэсэн тайлан, илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУСтандарт, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн, зөв, шударга илэрхийлэгдэж “Зөрчилгүй санал дүгнэлт”-ийн Нийслэлийн Аудитын газрын 2017 оны 3 дугаар сарын 24-ний өдрийн 803 дугаар Аудитын гэрчилгээгээг Нийслэлийн Аудитын газрын дарга С.Энхбаатар дүүргийн Засаг дарга бөгөөд Төсвийн ерөнхийлөн захирагч Ж.Эрдэнэбатад 2017 оны 3 дугаар сарын 31-ний өдөр гардуулан өглөө.

Хүрч буй үр дүн: Сургалт, зөвлөгөөнийг төлөвлөгөөний дагуу үе шаттай зохион байгуулах ажил зохих хэмжээгээр хийгдэж, боловсон хүчний мэргэжлийн мэдлэг, чадавхийг дээшлүүлсэн.

1.6.2 Аж ахуйн нэгж байгууллагуудын дунд санхүү, татварын хуулийн чиглэлээр хамтарсан сургалтыг зохион байгуулах.

Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институтээс ирүүлсэн 2017 оны 1/98 тоот албан бичгийн дагуу дүүргийн төсөвтэй харилцагч аж ахуйн нэгж байгууллагын 70 нягтлан бодогчдыг 2016 онд шинээр батлагдаж, өөрчлөлт орсон стандарт, хуулийн өөрчлөлтийн сургалтанд хамруулсан.

Мэргэжлийн Нягтлан бодогчдын ёс зүйн дүрмийн дагуу Тангараг өргөх ёслолын үйл ажиллагаа 2017 оны 5 дугаар сарын 10-ны өдрийн 15 цагт Тусгаар тогтнолын ордны бага танхимд амжилттай зохион байгуулагдлаа. Тангараг өргөх ёслолын ажиллагаанд Чингэлтэй дүүргийн Орон нутгийн болон тусгай зориулалтын шилжүүлгийн төсөвт байгууллагуудын 19 нягтлан бодогч, аж ахуйн нэгж байгууллагуудын 31 нягтлан бодогч нар оролцлоо.

Мөн тангараг өргөх сёлолын арга хэмжээнд “Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм”-ээр Монголын Нягтлан Бодох Хүрээлэнгийн тэргүүн Монгол улсын

Гавьяат эдийн засагч, доктор, профессор Л.Дондог лекц уншиж, мэргэжлийн үнэтэй зөвлөмж өгсөн нь мэргэжлийн боловсон хүчний цаашид ажиллах урам зориг, идэвхийг өрнүүлсэн сайхан үйл явдал боллоо.

Хүрч буй үр дүн: Мэргэжлийн байгууллагуудтай хамтран санхүү, бүртгэл тооцооны ажилтны мэдлэг, мэргэжлийн чадавхийг дээшлүүлсэн.

1.6.3 Төсөвт байгууллагуудын нягтлан бодогч нарын дунд санхүү, удирдлага, нягтлан бодох бүртгэлийн чиглэлээр сургалт зохион байгуулах.

Хэрэгжилт, биелэлт:

Монгол улсын Сангийн Яамны Төрийн сангийн газар, Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс хамтран ЗГУНСистем, Төрийн сангийн нэгдсэн дансны тогтолцооны шинэчлэлийн ажлын хүрээнд “Засгийн газрын санхүүгийн тайлан”- г хүлээн авах, онлайнаар илгээх, тушаах, нэгтгэх, баталгаажуулах, Төсөвт байгууллагын санхүүгийн “Э-ТАЙЛАН”-гийн шинэ программаар 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг гаргах талаарх болон программын агуулгаарх дэлгэрэнгүй сургалтыг 2017 оны 01-р сарын 26-ний өдрийн 10.00 цагт дүүргийн Засаг даргын Тамгын газрын “Хурлын танхим”-д зохион байгууллаа.

Сургалтанд Сангийн Яамны Төрийн сангийн газрын мэргэжилтэн Л.Эрдэнэбадрах, Санхүүгийн программ хангамжийн “Санхүүгийн тооцоолох групп”-ийн нэвтрүүлэлтийн ажилтан Б.Булганчимэг, Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн Ерөнхий нягтлан бодогч Н.Дэлгэрмаа, ТМССХариуцсан мэргэжилтэн Л.Батзориг, Орон нутгийн болон тусгай зориулалтын шилжүүлэгийн 67 төсөвт байгууллагуудын 50 нягтлан бодогч нар тус тус оролцлоо.

Сургалтыг хөтөлбөр, программын дагуу Төсөвт байгууллагын санхүүгийн аудитлагдсан тайланг Монгол улсын Сангийн Яамны Төрийн сангийн нэгдсэн дансны тогтолцооны “Э-ТАЙЛАН” сайтад онлайнаар шивж илгээх, хянуулах, баталгаажуулах үйл ажиллагааг хийх нэгдсэн заавар журам, санхүүгийн тайлангийн “Acolous” программд орсон өөрчлөлтийг сэргээх, цаашид анхаарах асуудлуудыг дэлгэрэнгүй хэлэлцэж, санал, дүгнэлтээ солилцож ажиллаа.

Дүүргийн төсөвтэй харилцагч орон нутгийн болон тусгай зориулалтын шилжүүлгийн төсөвт байгууллагуудын нягтлан бодогч нарын 2017 оны нэгдсэн зөвлөгөөнийг удирдамж, хөтөлбөрийн дагуу 2017 оны 5-р сарын 19-ны өдөр “Бишрэлт-холдинг” ХХК-ны байранд зохион байгуулан гүйцэтгэлээ.

Нэгдсэн зөвлөгөөнд дүүргийн Засаг дарга Ж.Эрдэнэбат, Засаг даргын Тамгын газрын дарга А.Дамцагдорж, Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга Ж.Орхонбаяр, Дотоод аудитын албаны дарга Ц.Жаргалтай, Санхүү, төрийн сангийн хэлтсийн мэргэжилтэнгүүд, төсөвт 67 байгууллагуудын нягтлан бодогч нар тус тус оролцлоо.

Нэгдсэн зөвлөгөөнөөр “Дүүргийн 2016 оны Орон нутгийн болон тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүгийн нэгтгэсэн тайланд санхүүгийн тайлангийн аудит хийж, аудитаас гарсан дүгнэлт, зөвлөмж, тайланд дурдагдсан зөрчил, дутагдалыг арилгах арга зам, зөвлөмжийг хэрэгжүүлэхэд зохион байгуулах ажлын чиглэл, түүний үр дүн”-гийн талаар, “Дотоод аудитын төсвийн байгууллагад 2016 онд хийсэн шалгалтын ажлын үр дүн, цаашидын чиг

хандлага"-ын талаар, "2016 онд зохион байгуулсан сургалт, зөвлөн туслах, мэргэжил арга зүйгээр хангах, шалган зааварчлах ажил, мэдээ судалгаа авалтын ажлын үр дүн, цаашид анхаарах асуудал"-ын талаар тус тус хэлэлцлээ.

Зөвлөгөөнд дүүргийн Засаг дарга Ж.Эрдэнэбат, Засаг даргын Тамгын газрын дарга А.Дамцагдорж нар дүүргээс 25 жилийн ой угтаж хийж буй бүтээлч ажил, цаашид хэрэгжүүлэх ажлын талаар дэлгэрэнгүй үг хэлж, олон жил үр бүтээлтэй ажилласан нягтлан бодогч нарт дүүргийн 25 жилийн ойн медаль гардуулсан нь Санхүү, бүртгэл тооцооны ажилтны цаашид ажиллах урам зоригийг сэргээсэн сайхан үйл явдал болж өндөрлөлөө.

Мэргэжлийн Нягтлан бодогчдын ёс зүйн дүрмийн дагуу Тангараг өргөх ёслолын үйл ажиллагаа 2017 оны 5 дугаар сарын 10-ны өдрийн 15 цагт Тусгаар тогтнолын ордны бага танхимд амжилттай зохион байгуулагдлаа. Тангараг өргөх ёслолын ажиллагаанд Чингэлтэй дүүргийн Орон нутгийн болон тусгай зориулалтын шилжүүлгийн төсөвт байгууллагуудын 19 нягтлан бодогч, аж ахуйн нэгж байгууллагуудын 31 нягтлан бодогч нар оролцлоо.

Мөн тангараг өргөх сёллын арга хэмжээнд "Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм"-ээр Монголын Нягтлан Бодох Хүрээлэнгийн тэргүүн Монгол улсын Гавьяат эдийн засагч, доктор, профессор Л.Дондог лекц уншиж, мэргэжлийн үнэтэй зөвлөмж өгсөн нь мэргэжлийн боловсон хүчний цаашид ажиллах урам зориг, идэвхийг өрнүүлсэн сайхан үйл явдал боллоо.

Нийслэл дэхь Төрийн аудитын газартай хамтран зохион байгуулах дүүргийн орон нутгийн болон тусгай зориулалтын шилжүүлгийн төсөвт байгууллагуудад 2017 оны явцын болон гүйцэтгэлийн аудит хийх нээлтийн ажиллагаа, сургалт-семинарыг 2017 оны 9-р сарын 20-ны өдрийн 10.00 цагт дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг "Тахь-Ко" ХК-ны "ANCORE" сургалтын төвийн зааланд зохион байгууллаа. Нээлтийн үйл ажиллагаа болон сургалт-семинарт: Дүүргийн Засаг дарга бөгөөд Төсвийн ерөнхийлөн захирал Ж.Эрдэнэбат, Нийслэл дэхь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор С.Энхбаатар, Санхүүгийн 1-р хэлтсийн дарга бөгөөд Аудитын менежер Д.Отгонбаяр, ахлах аудитор А.Цогбаяр, аудитор Ц.Саранцэцэг, И.Эрдэнэцэцэг, Санхүү, төрийн сангийн хэлтсийн мэргэжилтэнгүүд, төсөвт 67 байгууллагуудын төсвийн шууд захирагч, нягтлан бодогч нар оролцлоо.

Дүүргийн Засаг дарга бөгөөд Төсвийн ерөнхийлөн захирагч Ж.Эрдэнэбат үйл ажиллагааг нээж, дүүргийн нэгтгэсэн санхүүгийн тайлангийн дүгнэлт, гарсан зөрчил дутагдлын явц байдал, бүртгэл, санхүүгийн хууль тогтоомж, заавар, журмын хэрэгжилтийг хангах, анхан шатны бүртгэл хөтлөлт, цаашид анхаарах асуудлаар үг хэлж, үүрэг даалгавар, зөвлөгөө, чиглэл өгч, санал бодлоо илэрхийллээ.

Мөн Төрийн аудитын байгууллагын шинэчлэл, цаашидын ажлын чиг үүргийн талаар Нийслэл дэхь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор С.Энхбаатар үг хэлж, Санхүүгийн 1-р хэлтсийн дарга бөгөөд аудитын менежер А.Цогбаяр 2016 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн дүгнэлт, зөвлөмжөөр гарсан зөрчил дутагдал, түүний арилгах арга зам, цаашид анхаарах асуудал, явцын болон гүйцэтгэлийн аудитын удирдамж, хөтөлбөр,

үйл ажиллагааг зохион байгуулж хэрэгжүүлэх талаар дэлгэрэнгүй мэдээлэл хийж, арга зүй зөвлөмжөөр хангах ажлыг зохион байгуулсан байна.

Дүүргийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсээс Монгол улсын Сангийн Яамны Төсвийн бодлого зохицуулалт, төлөвлөлтийн газартай хамтран дүүргийн орон нутгийн болон тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын нягтлан бодогч нарт 2017 оны 9 дүгээр сарын 27-ны өдөр “2018 оны төсвийн төлөвлөлт, тухайн жилийн төсвийн хүлээгдэж буй гүйцэтгэлийг “Төсвийн төлөвлөлтийн мэдээллийн нэгдсэн систем”-ийг ашиглан гүйцэтгэх тухай нэгдсэн сургалтыг зохион байгууллаа.

Уг сургалтанд Монгол улсын Сангийн яамны Төсвийн бодлого зохицуулалт, төлөвлөлтийн газрын Төслийн зөвлөх Д.Долоонжин, н.Бүжинлхам, Санхүү, төрийн сангийн хэлтсийн төсвийн мэргэжилтэн Б.Даваадолгор, ерөнхий нягтлан бодогч Н.Дэлгэрмаа, төсвийн байгууллагуудын нягтлан бодогч нар оролцлоо.

Сургалтын гол агуулга нь Монгол улсын 2018 оны болон 2018-2020 оны төсвийн төслийн төлөвлөлт, тухайн жилийн ажлын урсгал, төсвийн төлөвлөлт, хуваарилалт, хяналт тавих, түүнд орох өөрчлөлтүүдийн мэдээллүүдийг “Төсвийн төлөвлөлтийн нэгдсэн систем”-д оруулж нэвтрүүлэх тухай мэдлэг олгох, чадавхийг бэхжүүлэхэд чиглэсэн ба хэтийн болон тухайн төсвийн жилийн ажлын урсгалыг системд хэрхэн гүйцэтгэх, ашиглах тухай ойлголтыг өгснөөрөө ач холбогдолтой боллоо.

Хүрч буй үр дүн: Нягтлан бодогч нарын мэдлэг мэргэжлийн чадавхийг дээшлүүлж, мэргэжлийн хууль эрх зүйн онол, практик хосолсон арга зүй зөвлөмжөөр ханган ажилласан.

Танилцсан:

Засаг даргын Тамгын газрын
дарга А.Дамцагдорж

Санхүү, төрийн сангийн хэлтсийн
дарга Ж.Орхонбаяр

Тайланг боловсруулсан:

Санхүү, төрийн сангийн хэлтсийн
мэргэжилтэн Л.Батзориг

Хяналт, шинжилгээ үнэлгээ хариуцсан
мэргэжилтэн Ш.Цэцэгмаа951

